

ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2021.12.10

Хараат

№	Хэрэгжүүлэх ажил	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
1	Ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөөг батлуулах	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Ёс зүйн зөвлөлийн 2021 оны ажлын төлөвлөгөөг зөвлөлийн даргаар 2021.03.10-ны өдөр батлуулан гишүүдэд танилцуулсан.	100
2	Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор гадаад, дотоодын сургалтад хамруулах, зохион байгуулах	Сургалтын тоо Хамрагдсан албан хаагчдын тоо	НТБ-ын үндэсний төвөөс зохион байгуулсан “Ёс зүйн боловсрол” олгох 3 хоногийн цахим сургалтанд НТБ-ын багш Н.Оюунцэцэг хамрагдан сургуулийн нийт 22 багш, ажилтанд “Ёс зүйн хариуцлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Цэцэрлэгийн 11 багш, ажилтнуудтай 2021.10.18-нд “Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм”-ийг хэрэгжүүлж ажиллах “Батламж” гардуулж гарын үсэг зурж баталгаажуулж ажилласнаар сахилга, ёс зүйн доголдол, зөрчил гараагүй. БСУГ, БМДИ-ээс зохион байгуулсан “Багшийн ёс зүй, эерэг хандлага”, “Хувь хүний хөгжил ёс зүй” сэдэвт сургалтад эрхлэгч, багш нар 100% хамрагдан дээрх сэдвийн хүрээнд ажлын байранд сургалтыг зохион байгуулсан. Аймгийн тэргүүний цэцэрлэгийн эрхлэгч нараас “Ёс зүйн хандлага” сургалтыг авч, ажиллаж буй арга туршлагаас танилцуулсан. ЭМТ-ийн 15 албан хаагчдад эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ сэдвээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Соёлын төвөөс “Төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүй” сэдвээр дотоод сургалт зохион байгуулж 5 албан хаагч хамрагдаж ёс зүйн зөрчилгүй ажиллалаа. ЗДТГ-аас 2021.10.28-нд төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтнууд болон төрийн захиргааны албан хаагчдын дунд “Төрийн албан хаагчийн манлайлал” уулзалт, ярилцлагыг зохион байгуулж Рояль ОУИС-ын төрийн удирдлагын хөтөлбөрийн удирдагч, доктор Б.Байгалмаа лекц зохион байгуулж, ЕБС-ийн захирал, МУГБагш Д.Октябрь “Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага” сэдвээр сургалт зохион байгуулж 31 албан хаагч хамрагдлаа.	100

3	Албан хаагчидтай ёс зүй, сахилга, хариуцлагын гэрээ байгуулах	Байгуулсан гэрээний тоо	ЗДТГ-аас 17 төрийн албан хаагчидтай, ЕБС-аас 22 багш, ажилчидтай 2, цэцэрлэгийн 11 багш, ажилчидтай, соёлын төвөөс 5 албан хаагчидтай “Сахилга хариуцлага, ёс зүйн” гэрээг байгуулсан.	100
4	Шинээр ажилд орсон албан хаагчдад байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг танилцуулах	Танилцсан албан хаагчийн тоо	ЗДТГ-т шинээр ажилд орсон 7 албан хаагчид ЗДТГ-ын үйлчилгээний стандарт, байгууллагын дотоод журмыг уншиж судлуулсан.	70
5	Албан хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой иргэдээс ирсэн гомдлыг хэлэлцэж шийдвэрлэх, дүгнэлт гаргах	Шийдвэрлэлтийн хувь	Төрийн албан хаагчийн ёс зүй, үйл ажиллагаатай холбоотой ямар нэг гомдол мэдээдэл иргэдээс ирээгүй ба төрийн үйлчилгээг аливаа хэлбэрийн ялгаварлал, гадуурхалгүй адил тэгш хүргэх, зарчмыг баримтлан ажиллалаа.	100
6	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм болон ажлын байранд дагаж мөрдөх хэм хэмжээ, дотоод журмын ёс зүйтэй холбоотой заалтуудыг албан хаагчдад танилцуулах, баталгаажуулах	Танилцсан албан хаагчдын тоо	Төрийн албаны үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг баримтлан, иргэдтэй эелдэг харьцах, адил тэгш хандаж, хүнд суртал, чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчлэх соёлыг хэвшүүлэхээр ЗДТГ-ын үйлчилгээний стандартыг хамт олны хурлаар хэлэлцэн ЗДТГ-ын даргын 2021 оны А/03 тоот тушаалаар баталж мөрдүүлж ажилласан. Мөн бүх албан хаагчидтай ёс зүй, сахилга, хариуцлагын гэрээ байгуулж, ЗГ-ын 2018 оны 258-р тогтоол, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм зэрэг төрийн албан хаагчдын үйл ажиллагаандаа мөрдөж ажилах дүрэм, журам, стандартыг гийг багтаасан “Албан хаагчдын ёс зүй, сахилга, хариуцлагын гарын авлага”-ыг бэлтгэн ширээний ном болгосон.	100
7	Ажил хэрэгч хувцаслалт, байгууллагын соёлын талаар албан хаагчдад сургалт зохион байгуулах	Сургалтын тоо	ЗДТГ-ын даргын 2021.01.12-ны өдрийн А/03 тоот тушаалаар “Байгууллагын үйлчилгээний стандарт”-ыг батлан мөрдөж ажиллалаа. Стандарт батлагдсанаар төрийн албан хаагчдын цаг ашиглалт, хувцаслалт дүр төрх, ажлын сахилга хариуцлага дээшилсэн. Соёлын төвөөс байгууллагын соёлыг дээшлүүлэх зорилгоор нэр хаяг болон албан хаагчдын энгэрийн тэмдгийг шинэчилж, тамхины цэгийг тогтоож шинэчилсэн. Цэцэрлэгээс байгууллагын соёлыг түгээн дэлгэрүүлэх, албан хаагчдыг эерэг хандлага манлайллыг дээшлүүлэхэд анхаарч аймгийн Улсын тэргүүний 3	100

			цэцэрлэгийн эрхлэгч Мөнхтуяад хүсэлт хүргүүлж, “Байгууллагын соёл” сургалтыг авч, ажиллаж буй арга туршлагатай танилцсан. Мөн байгууллагадаа нэг нэгэндээ ажлын амжилт, урам хайрласан “Мэндчилгээний булан”-г ажиллууллаа.	
8	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг мэдээллийн самбар болон цахимд хуудсанд байршуулах	Тоо	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг мэдээллийн самбар болон цахимд хуудсанд байршуулсан.	100
9	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцож ЗДТГ-т хүргүүлэх	Хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөнд нийт 9 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилтийг тооцоход 96,6%-ийн биелэлттэй байна.	100
ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ				96,6

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР